

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2024 оны 01 сарын 02-ны өдөр

Дугаар ...

БА-023/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 1 давхар 6.0м*4.8м хэмжээтэй операторын барилга, 30м³ хүчин чадалтай 2 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 11 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 10 сарын 23-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/08/29 огноо, БА32024/0437 дугаар

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: 1705-ШТС-0891

2.3. Захиалагч: Тэс Петролиум ХХК оноосон нэр, 9011068065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2658445 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, нарны зам, Тэс төвийн байр, 201 тоот, 70113003 холбоо барих утас, Info@tespetroleum.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Тэс Петролиум ХХК оноосон нэр, 9011068065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2658445 регистрийн дугаар, БУ16-219/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, нарны зам, Тэс төвийн байр, 201 тоот, 70113003 холбоо барих утас, Info@tespetroleum.mn цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Эм Пи Ай Консалтантс ХХК оноосон нэр, 9011099068 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2662671 регистрийн дугаар, ЗТ11-368/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Үйлдвэрийн бүс, 52-р байр, 976-11-310816 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Тэс Петролиум ХХК оноосон нэр, 9011068065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,

УСНАДТ АШИГЛАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

2658445 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, нарны зам, Тэс төвийн байр, 201 тоот, 70113003 холбоо барих утас Info@tespetroleum.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьгүй 1 давхар 6м х 4.8м хэмжээтэй операторын барилга, газрын тосны бүтээгдэхүүний 60м³ хүчин чадал бүхий шатахуун түгээх станцын зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:


Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.



3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 4 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 22 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.


Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 1 давхар 6м х 4.8м хэмжээтэй операторын барилга, газрын тосны бүтээгдэхүүний 60м3 хүчин чадал бүхий шатахуун түгээх станцын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, Тэс Петролиум ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 6м х 4.8м хэмжээтэй операторын барилга, газрын тосны бүтээгдэхүүний 60м3 хүчин чадал бүхий шатахуун түгээх станцын барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч


Нарийн бичгийн дарга: Тэс Петролиум ХХК-ийн гүйцэтгэх захирал



(А.Мөнгөн)

(Ц.Майдар)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




ШАЛГАЛТЫН
ЗАР
МЖИЙГ АШИГЛАЛТАНД
Х КОМИСС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРОО, ТЭС ПЕТРОЛИУМ ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬГҮЙ 1 ДАВХАР 6М Х 4.8М ХЭМЖЭЭТЭЙ ОПЕРАТОРЫН
БАРИЛГА, 30МЗ ХҮЧИН ЧАДАЛТАЙ 2 ШИРХЭГ ДАЛД САВ БҮХИЙ ШАТАХУУН
ТҮГЭЭХ СТАНЦЫН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 10 дугаар сарын 23

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, Тэс Петролиум ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 6.0м*4.8м хэмжээтэй операторын барилга, 30мЗ хүчин чадалтай 2 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын операторын барилгын байр дээр 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 09 цагт 11 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11 цагт дуусав.



Хуралд:

- | | |
|--|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Тэс Петролиум ХХК-ийн Гүйцэтгэх захирал | Ц.Майдар |
| 3. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт Хяналтын хэлтсийн Газрын тос хийн хяналтын улсын ахлах байцаагч | Т.Мөнхболд |
| 4. Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн дарга, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | Б.Найрамдал |
| 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техникийн хяналтын инженер | Б.Цэрэннадмид |
| 6. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар Дэд бүтэц, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн | Н.Болор-Эрдэнэ |
| 7. Нийслэлийн Онцгой байдлыг газар Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч | Б.Даваасүрэн |
| 8. Үндэсний Төв Архив , Архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 9. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 10. Зураг төсөл зохиогч байгууллага Эн Пи Ай Консалтантс ХХК-ийн зургийн инженер | Ц.Мөнх-Эрдэнэ |
| 11. Барилгын ажил гүйцэтгэгч Тэс Петролиум ХХК-ийн Ерөнхий инженер | Н.Лхагвасүрэн |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 11
- Хүрэлцэн ирсэн - 11
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 11

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, Тэс Петролиум ХХК-ийн захиалгатай, зоорьгүй 1 давхар 6.0м*4.8м хэмжээтэй операторын барилга, 30мЗ хүчин чадалтай 2 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын барилгыг ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Газрын тос хийн хяналтын улсын ахлах байцаагч **Т.Мөнхболд:**

- Түгээгүүрийн баталгаажилт хийлгэх.
- Савнуудыг ГТБТХ-ийн холбогдох заалтын дагуу улсын бүртгэлд хамруулж паспортжуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн дарга- Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **Б.Найрамдал:**

- Цахилгаан эрчим хүчний ил, далд акт холбогдох баримт бичгийг бүрэн бүрдүүлж архивт хүлээлгэн өгөх.
- 0,4 кв-ын шитний схем зураг, хаяг вирк бүрэн хийх
- ШТС-ын баруун талд нэг гэрэлтүүлэг шинээр тавиулах саналтай.
- Халаалтын системийн зааварчилгаа угсралтын баримт бичгийг шалгуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.


Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техникийн хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- ШТС-ын цахилгаан хуваарилах самбарт хаяг бичиглэл, схем байршуулах
- Холболтын протокол шалгуулах
- Гаднах ЦДКШ-г нийслэлийн мэдээллийн санд бүртгүүлэх акт шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газар, Дэд бүтэц, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Гадна холбооны техникийн нөхцөлгүй тул угсралт хийгдээгүй.
- Операторын барилгад интернэт сүлжээ, кабелийн телевиз, телефон сүлжээ шаардлагагүй талаар авторын дүгнэлт гаргах.
- Холбоо дохиоллын зургийн магадлалд оруулсаныг шалгуулах



Нийслэлийн Онцгой байдлын газар, гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах/ байцаагч хошууч **Б.Даваасүрэн:**

- Зэргэлдээх айл болон барилга байгууламжид албан бичиг өгөх.
- ОБЕГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 277/06-14 тоот дүгнэлтийн дагуу дутуу ажлаа хийж гүйцэтгэх.
- Галын дохиоллын систем шалгасан акт фото зураг хавсаргах.
- Гал унтраах анхан шатны багаж зэвсэглэмж MNS5566:2020 стандартын дагуу операторын байранд байрлуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм, нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **О.Ундрах:**

- Операторын барилгын хучилтыг зураг төслийн дагуу цутгамал хучилт хийгдээгүй,
- байгууллага тайлбар, албан бичиг ирүүлж, зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгах.
- Захиалагчийн нэгдсэн дүгнэлтийг шинэчлэх /толгой/
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг төлөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөл: “Тэс Петролиум” ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Ц.Майдар:**

- Байнгын ашиглалтанд хүлээн авахад татгалзахгүй зүйлгүй болно.

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл: “Тэс Петролиум” ХХК-ийн ерөнхий инженер **Н.Лхагвасүрэн:**

- Чингэлтэй дүүргийн 10-р хороонд байрлах манай компанийн ШТС-97 “Тэс Петролиум” ХХК-ийн 60 мЗ-ын хүчин чадалтай ШТС-ын барилга байгууламжийн чанартай сайн гүйцэтгэсэн тул улсын комиссын гишүүний саналаар биелэлт хангаж ажиллана.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Эм Пи Ай Консалтантс ХХК-ийн Зургийн инженер **Ц.Мөнх-Эрдэнэ:**

- Галын усан сангийн дүүргэлтийг хангаж, байнгын бэлэн байдалд байлгах

Үндэсний төв архив, Архивын эрхлэгч **Я.Чулуун:**

- Тус барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичгийг бүрэн бүрдэлтэйгээр эх хувийг архивд хүлээлгэн өгөх.
- Барилга угсралтын ил, далд ажлын акт, улаан дэвтрийг баталгаажуулах.
- Үндсэн баримтыг архивын заавар журмын дагуу цэгцлэх /дотоод товчоо үйлдэх, хуудас дугаарлах/

Т ШАЛГАЛТ
ТАВАР
уламжийг ашиг
улах комисс

Хяналтын шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал**:

- БНБД11-04-16 дагуу зохиогч дүгнэлт өгөх.
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх.
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу операторын барилгын байшин өөрчлөгдсөнд зохиогч, захиалагч, гүйцэтгэгч тайлбар албан тоот ирүүлэх /өөрчлөлтийн зураг гарган батлуулах/
- Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгүүлсэн акт хянуулах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, Тэс Петролиум ХХК-ийн захиалгатай, зoorьгүй 1 давхар 6.0м*4.8м хэмжээтэй операторын барилга, 30м³ хүчин чадалтай 2 ширхэг далд сав бүхий шатахуун түгээх станцын барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Тэс Петролиум ХХК-ийн
гүйцэтгэх захирал



(Ц.Майдар)

